**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/317 Номгон

Сум, байгууллагын түүхэн тэгш ой
тэмдэглэх тухай захирамжид өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гурванбулаг сумын Засаг даргаас 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/89, Гурванбулаг сумын хүүхдийн цэцэрлэгээс 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Сум, байгууллагын түүхэн тэгш ой тэмдэглэх тухай” аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/78 дугаар захирамжийн хавсралтад Гурванбулаг сумын цэцэрлэгийн түүхт 60 жилийн ойг 2026 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэснийг 2026 оны 07 дугаар сарын 08-09-ний өдрүүд болгон өөрчилсүгэй.

2.Сум, байгууллага байгуулагдсан түүхэн хугацааг тогтоолгохдоо нотлох баримтад үндэслэсэн санал ирүүлж байхыг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

626010875

ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠤᠬᠠᠭᠠᠨ ᠤ
ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠘ ᠡᠳᠦᠷ — ᠳᠤᠭᠠᠷ A/36 — ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ

ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ

ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠐᠙ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠙.᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ᠂ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠐᠙.᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠬᠤ ᠨᠢ᠄

᠑. ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠒᠐᠒᠕ ᠣᠨ ᠤ ᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠒ — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ A/᠑᠒᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠢᠶᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠵᠢᠭᠤᠮ ᠢ ᠮᠦᠷᠳᠡᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠵᠦ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠶᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠦᠦᠷᠭᠡ ᠳᠠᠭᠠᠯᠭᠠᠰᠤᠭᠠᠢ᠃

᠒. ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠶᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠶᠠᠭᠠᠮᠤᠨ ᠤ ᠲᠥᠷᠢᠢᠨ ᠨᠠᠷᠢᠯᠠᠭ ᠳᠤ ᠳᠠᠭᠠᠯᠭᠠᠰᠤᠭᠠᠢ᠃

᠓. ᠳᠡᠭᠡᠷᠡᠬᠢ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠭᠠᠷᠤᠭᠰᠠᠨ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠠᠳ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠒᠐᠒᠔ ᠣᠨ ᠤ ᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠙ — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ A/᠓᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠭᠦᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠤᠭᠠᠴᠠᠭᠠᠰᠤᠭᠠᠢ᠃

ᠰᠠᠶᠢᠳ

ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠶᠢᠳ᠂ ᠡᠷᠳᠡᠮ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠤᠬᠠᠭᠠᠨ ᠤ